




ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Дорноговь аймгийн
нийгэм, эдийн засгийн
танилцуулга

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2017/10



Мэдээллийн нэгдсэн лавлах: WWW.1212.MN

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**


(2017 оны 10 дугаар сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт**1.1 Хүн ам**

Дорноговь аймгийн хэмжээнд 2017 оны эхний 10 сард 1071 эх амаржиж, 1078 хүүхэд шинээр мэндэлжээ. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 10.5 хувиар буюу 126-аар, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 10.5 хувиар буюу 127-оор буурсан байна. 2017 оны 10 сарын байдлаар 289 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс 4.9 хувиар буюу 15-аар буурчээ.

Хүн амын цэвэр өсөлт 789 болж 2016 оны мөн үеийнхээс 12.4 хувиар буюу 112-оор буурчээ. 1000 хүнд ногдох төрөлт 16.6, нас баралт 4.5 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 2.4 пунктээр буурч, нас баралт 0.1 пунктээр өссөн байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2014-2017 оны эхний 10 сард



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдэл 8.3 байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.3 пунктээр буурчээ.

**1.2 Эрүүл мэнд**

Он гарсаар 288.2 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 12.5 хувиар, 9.5 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 24.6 хувиар буурч, 13.2 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 1.5 хувиар илүү байна.


Эхний 10 сард 1304 эх жирэмсний хяналтанд орсны 86.0 хувь буюу 1122 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс пунктээр нэмэгдсэн байна.



Түргэн тусламжийн дуудлага 15.3 мянган удаа гарсны 2.6 мянга буюу 17.0 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 8.9 хувиар, алсын дуудлага 13.3 хувиар тус тус буурсан байна.

Он гарсаар ослын улмаас 2246 хүн бэртэж, 71 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 256 (12.9%), нас барсан хүний тоо 7 (10.9%) хувиар тус тус нэмэгджээ.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2017 оны эхний 10 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд хавдар 24.9 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 26.3 хувь, осол гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралт 24.6 хувь, хоол шингээх эрхтний өвчин 7.6 хувь, мэдрэлийн тогтолцооны өвчин 3.1 хувь, бусад шалтгаан 13.5 хувийг эзэлж байна.

Халдварт өвчний 609 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 60.8 хувиар буюу 946-аар буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад тэмбүү 41.9 хувь, вируст гепатит 42.9 хувь, трихоминиаз 20.0 хувь, бусад төрлийн халдварт өвчин 78.6 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

1.3. Боловсрол

2017/2018 оны хичээлийн жилд ЕБС-д нийт 3212 суралцагч элсэн суралцсан нь өмнөх оны мөн үеэс 21.3 хувиар буюу 563-аар нэмэгдсэн байна. 1 дүгээр ангийн 2017/2018 оны хичээлийн шинэ жилд 1556 хүүхэд элсэн суралцсан нь өмнөх оны мөн үеэс 13.5 хувиар буюу 185-аар нэмэгдсэн байна.




1.4 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2017 оны 10 сарын эцэст 1312 болсны 1300 (97.7%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 12 (2.3%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 265 (16.0) хүнээр өсч, өмнөх сараас 243 (15.6%) хүнээр буурч 1312 болсны 660 (50.3%) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 684 (52.1%) нь Сайншанд суманд, 251 (19.1%) нь Замын-Үүд суманд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 52.0 хувь нь бүрэн дунд, 23.6 хувь нь дээд, 6.1 хувь нь бүрэн бус дунд, 7.3 хувь нь тусгай дунд, 8.1 хувь нь техник болон мэргэжлийн, 1.0 хувь нь бага, 1.4 хувь нь боловсролгүй, 0.5 хувь нь магистр/докторын, иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2017 оны 10-р сард



Хөдөлмөрийн хэлтэст 2017 оны 10-р сард 1244 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 449 иргэн ажилд зуучлагдан орж, 752 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. Эдгээр үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахд шинээр бүртгүүлсэн 509 (69.3%) хүн, ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 133 (84.9%) хүнээр буурч, ажилд зуучлагдан орсон иргэд 86 (23.7%) хүнээр нэмэгдсэн байна

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 652 ажлын байрны 18.7 хувь нь мэргэжилтэн, 1.4 менежер хувь, 16.6 хувь худалдаа, үйлчилгээний ажилтан, 19.3 хувь нь энгийн ажил, 17.1 хувь нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 4.6 хувь нь контор үйлчилгээ, 14.7 техникч болон туслах / дэд мэргэжилтэн, 7.6 хувь нь бусад ажилтны захиалга байна.



Зураг. Бүртгээлгүй ажилгүй иргэд сумаар



Зураг. Шинээр ажлын байранд орсон иргэд салбараар



Ажил хайгч 449 иргэн ажилд зуучлагдан орсоны 139 (31.0%) нь эмэгтэйчүүд байна.



1.5 Нийгмийн даатгал, халамж

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны эхний 10 сард 22281.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2051 (10.1%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2017 оны эхний 10 сард өмнөх оны мөн үеэс 2051.0 сая төгрөгөөр нэмэгдэхэд Тэтгэврийн даатгал 1193.5 (9.8%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 140.1 (10.2%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгал 475.3 (27.3%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгал 286.4(87.9%) өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2017 оны 10 сард





Нийгмийн даатгалын сангийн зарлага 32493.6 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 2400.5 (8.0%) сая.төг-өөр илүү байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 23057.4 сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 1813.9 сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 5061,6 сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 1796.0 сая.төг, ажилгүйдлийн даатгалын сангаас 764.7 сая төгрөгийг зарцуулжээ.


Зураг. Нийгмийн даатгалын зарлага, сая төг



Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас оны эхний 10 сард нийгмийн халамжийн сангаас 18424 иргэнд 4919.1 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 3429 (22.9%)-аар, олгосон тэтгэвэр тэтгэмж 358.4 (14.3%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2017 онд 8388 хүн хамрагдсан нь өмнөх оноос 4009 (91.6%)-өөр нэмэгдэж, олгосон тэтгэвэрийн хэмжээ 542.3 (60.4%) мянган төгрөгөөр нэмэгджээ. Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжид 8653 иргэнд 1792.5 мянган төгрөг олгосон байна.

Зураг. Хүний тоо

Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /мян төг/





1.6 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр оны эхний 10 сарын байдлаар 589 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 181 хүн гэмтэж, 28 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 43 (7.9%)-өөр нэмэгдсэн, нас барсан хүний тоо 1 (3.4%)-аар нэмэгдэж, гэмтсэн хүний тоо 48 (20.9%) -оор буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 45 (23.7%)-аар, авилгын гэмт хэрэг 18 (85.7%)-аар буурч бусад төрлийн гэмт хэрэг нэмэгджээ.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 31.6 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 24.6 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 9.0 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 11.0 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 142 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.8 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Алтанширээ, Даланжаргалан, Дэлгэрэх, Сайхандулаан, Улаанбадрах, Хөвсгөл, Эрдэнэ сумдад буурч, бусад сумдад гэмт хэргийн тоо нэмэгдсэн байна.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар




Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 4142.4 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2305.5 (2.2 дахин) сая төгрөгөөр өссөн байна. Учирсан хохирлын 2488.2 (60.1%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 183 (31.1%) нь гэр сууцандаа, 142(24.1%) нь согтуугаар, 91 (15.4%) нь гудамж олон нийтийн газарт, 46 (7.8%) бүлэглэн, 99 (16.8%) хувийг эмэгтэй хүн, хүүхэд оролцон, 191 (32.4%) нь шөнийн цагаар /22-06 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 1374 хүн саатуулагдаж, 168 хүн баривчлагджээ.



Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 10 сард




Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт



2.1 Мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын кассын орлого 958.1 тэрбум төгрөг болж өмнөх оноос 12.3 хувь, цэвэр зарлага 908.6 тэрбум төгрөг болж 15.8 хувиар тус тус өссөн байна.

Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2016- 2017 он, мян.хүн





Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2016-2017 он, сая.төг




Иргэдийн мөнгөн хадгаламж 74.9 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1120.8 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1124.2 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчийн тоо 0.4 (0.5%) мянган хүнээр, хадгаламжийн үлдэгдэл 19.1 (34.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны 10 дугаар сарын эцэст 2503.7 сая төгрөг болж, өмнөх сараас 13.9 (0.6%) сая төгрөг нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 69.7(2.7%) сая төгрөгөөр буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдэлийн 1.3 хувийг эзэлж, өмнөх сараас 0.1 пунктээр нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 0.2 пунктээр буурчээ.

Чанаргүй зээл 10 дүгээр сарын эцэст 7920.4 сая төгрөг болж өмнөх сараас 216.6 (2.7%) сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 1882.5 (19.2%) сая төгрөгөөр буурсан. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.0 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.6 пунктээр буурсан байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2017.10 сард




Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2017.10 сард



2.2 Орон нутгийн төсөв

2017 оны 10 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 18588.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 96.5 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 50.5 хувиар буурсан байгаа нь улсын төсвөөс санхүүждэг тусгай зориулалтын шилжүүлэг болон орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих зардлын эх үүсвэрүүд 2017 оноос орлогын гүйцэтгэлийн дүнд нэгтгэгдэхгүй болсонтой холбоотой юм. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 80.2 хувийг татварын, 19.8 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2017 оны 10-р сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 3708.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 1803.0 (94.6%) сая.төг-өөр, төлөвлөгөөнөөс 2249.2 (2.5 дахин) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.



Хэрэглээний үнийн индекс 2017 оны 10 дугаар сард өмнөх сараас 0.2 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар өсчээ.


Ерөнхий индекс өмнөх сараас 0.2 хувиар буурахад: хүнсний бараа, ундаа усны бүлэг 1.8 хувь, хувцас, бөс бараа гутлын бүлэг 0,3 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг, 1,5 хувь, гэр ахуйн тавилга, бараа, 1,4 хувь, бусад бараа үйлчилгээний бүлэг 0,1 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний үнийн индексийн бусад бүлэг буюу эм тариа, эмнэлэгийн хэрэгсэл 8,2 хувь, тээврын бүлэг 0.7 хувиар нэмэгдсэн байна.

Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2017 оны 10 дүгээр сарын өөрчлөлт, өмнөх сартай харьцуулсанаар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2017 оны 10 дугаар сарын өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



3.1 Хөдөө аж ахуй

Оны эхний 10 сарын байдлаар төллөвөл зохих эх малын 76.5 хувь буюу 585.8 мянган толгой мал төллөж, төл бойжилт 99.9 хувьтай байна. Өмнөх оны мөн үеийнхээс төллөсөн хээлтэгч 88.2 (24.9%) мянган толгойгоор, төл бойжилт 117.2 (24.9%) мянган толгойгоор илүү юм.



2017 оны 10 сарын байдлаар 2224 толгой мал хорогдсоны 59.5 хувь нь өвчнөөр хорогдсон байна. Нийт хорогдолын 62.7 хувь нь Дэлгэрэх, Сайншанд суманд гарчээ.

Том малын зүй бус хорогдол 2017 оны 10-р сарын хэмжээнд 2.2 мянга болж, өмнөх оны мөн үеэс 95.5 (97.7%) мянган толгойгоор буурав. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзэхэд адуу 43 толгой, үхэр 258 толгой, тэмээ 31 толгой, хонь 1426 толгой, ямаа 466 толгой байна. Нийт хорогдсон малын 64.1 хувийг хонь, 20.9 хувийг ямаа эзэлж байна.

2017 оны 10-р сарын байдлаар 122.3 га талбайд тариалалт хийснээс төмс 30.9 га-д, хүнсний ногоо 67.4 га-д, тэжээлийн ургамал 10.5 га-д, техникийн ургамал 0.06 га-д тариалсан байна. Өмнөх оны мөн үеэс нийт тариалсан талбай 30 (32.5%) га, үүнээс тэжээлийн ургамлынх 3.6 (52.2%) га-гаар нэмэгдэж, төмс тариалсан талбай 8.1(24.0%) га, хүнсний ногоо 2.6 (5.1%) га-гаар буурсан байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн судалгаагаар Сайншанд суманд 10-р сард ноолуурын дундаж үнэ 60000 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 20000 (66.7%) төг,өөр өссөн байна. Харин ингэний сүү 2500 төг, тэмээний шир 5.0, адууны шир 15.0, хонь, ямааны арьс 15.0 мянган төг-ийн ханштай байна. Эр хонь 110.0-150.0 мян.төг, эр ямаа 70.0-120.0 мян.төг-өөр худалдаалагдаж байна.

Зураг. Том малын зүй бусын хорогдол, толгой



3.2 Аж үйлдвэр

Оны эхний 10 сард аж үйлдвэрийн салбарт 131424.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 207634.6 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 9.6 дахин, борлуулалт 24.3 дахин тус тус өссөн байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалтын өсөлтөд нүүрс олборлолт, цементний үйлдвэрлэл нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 3.8 хувийг төрийн, 96.2 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 3.8 хувь, компани 95.8 хувь, өрхийн аж ахуй 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан 2.2 мян.ккалаар, талх 42.0 мян.тонноор, сүүн бүтээгдэхүүн 14.7 мян.литрээр, хиам 0.4 тонноор, хэрчсэн гурил 9.6 мян.тонноор, цемент 263.6 мян.тонноор, модон эдлэл 8341.4 мян.төгрөгөөр, жижиг оёдол 3675.4 мян.төгрөгөөр, вакуум цонх 513.1 м2-аар, нүүрс 1073.3 мянган тонноор тус тус илүү үйлдвэрлэгджээ.



Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин Цаг уур

2017 оны 10 дугаар сард агаарын дундаж температур нийт сумдын нутгаар 3.6-7.4 хэм дулаан байлаа. Агаарын хамгийн их температур өдөртөө нийт сумдын нутгаар 22 – 25 хэм дулаан байлаа. Нийт нутгаар ОЖД-аас дулаан байсан. Энэ сард салхины хамгийн их хурд Сайншанд суманд 17 м/с, бусад сумдад 12-15 м/с байв. 10м/с-ээс дээш салхитай хоногийн тоо Сайншанд суманд 16 өдөр, Дэлгэрэх суманд 15 өдөр, Сайхандулаан, Иххэт, Улаанбадрах, Айраг,Өргөн сумдад 2-5 өдөр, бусад сумдын нутгаар 7-13 өдөр байлаа.

.10 дугаар сард Сайншанд, Эрдэнэ сумдад тунадасгүй, бусад сумдын нутгаар 1-4 өдөр 0,0-6,8 мм хур тунадас орж сарын нийлбэр хамгийн их тунадас Иххэт суманд 6,8 мм байв. Нийт сумдын нутгаар цасгүй байв.

_____ о Оо _____



АГУУЛГА

I. Аймгийн эдийн засаг, нийгмийн зарим гол нэгдсэн үзүүлэлтүүд

II. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдлын тухай статистикийн тоон мэдээлэл

(Эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар)

Нэг. Эрүүл мэнд

1.1 Эрүүл мэнд

1.2 Төрөлт, эх хүүхдийн эндэгдэл, сумаар

1.3 Халдварт өвчний гаргалт, сумаар

Хоёр. Боловсрол

2.1 Боловсролын үзүүлэлтүүд

Гурав. Хөдөлмөр эрхлэлт

3.1 Ажилгүй иргэдийн тоо, боловсролын түвшингээр

3.2 Ажилгүй иргэдийн тоо, сумаар

3.3 Ажлын байрны захиалга, эдийн засгийн салбарын ангилалаар

3.4 Ажлын байрны захиалга ажил мэргэжлийн ангилалаар

3.5 Ажилд зуучилсан иргэд, ажил мэргэжлийн ангилалаар

3.6 Шинээр бий болгосон ажлын байр, эдийн засгийн салбарын ангилалаар

Дөрөв. Нийгмийн даатгал, халамж

4.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, төрлөөр

4.2 Нийгмийн даатгалд заавал даатгуулагчийн тоо, олгосон тэтгэврийн хэмжээ

4.3 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо,

олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ

Тав. Гэмт хэрэг

5.1 Бүртгэгдсэн хэргийн тоо төрлөөр, аймгийн дүнгээр

5.2 Бүртгэгдсэн хэргийн тоо сумаар

Зургаа. Мөнгө, зээл

6.1 Мөнгөн гүйлгээ, зээл

6.2 Ипотекийн зээл, сарын эцэст

6.3 Хадгаламж, зээл, сумаар, 7 сарын эцэст

Долоо. Орон нутгийн төсөв

7.1 Орон нутгийн төсвийн орлого, сая төгрөгөөр

7.2 Орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөгөөр

7.3 Орон нутгийн төсвийн орлого, зарлага, сумдаар, сая төгрөгөөр

7.4 Улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн орлого, сая төгрөгөөр

Найм. Үнэ

8.1 Хэрэглээний үнийн индекс

8.2 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф

8.3 Гол нэрийн барааны үнэ, хөрш зэргэлдээ аймгуудаар

Ес. Хөдөө аж ахуй

9.1 Мал төллөлт, төл бойжилт

9.2 Том малын зүй бус хорогдол

9.3 ХАА-н бүтээгдэхүүний үнийн судалгаа, төрлөөр

9.4 Малын үнийн судалгаа, сумаар

9.5 ХУРААСАН УРГАЦ, сумаар, га-гаар

Арав. Аж үйлдвэр

10.1 Нийт бүтээгдэхүүн, борлуулалт, оны үнээр

10.2 Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн жигд ажиллагаа

10.3 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд салбараар

10.4 Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сумаар, нийт бүтээгдэхүүн гол нэр төрлөөр

Арван нэг. Байгаль орчин

11.1 Цаг уурын үзүүлэлт

Тэмдэглэлийн тайлбар:

(...) - тухайн тоо, баримт байхгүй

(0) - тайлант хугацаанд гүйцэтгэлгүй

(x) - энэ хүснэгтэнд тоо нөхөгдөхгүй

(.) - мэдээлэгдэх хугацаа болоогүй

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
(2017 ОНЫ 10 ДУГААР САРЫН БАЙДЛААР)

I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2014	2015	2016	2017	2017 - 2016	2017
							хувь
1. Бэлэн хүн ам	мянган хүн	63.5	63.1	66.6	67.4	0.8	101.2
- Төрсөн хүүхдийн тоо*	тоо	1257	1297	1205	1078	-127	89.5
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	308	275	304	289	-15	95.1
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	949	1022	901	789	-112	87.6
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	11	11	16	9	-7	56.3
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	8.8	8.4	13.3	8.3	-4.9	62.9
2. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	712	733	1470	609	-861	41.4
- 10000 хүнд ногдох	тоо	112.1	116.1	221	90	-130	40.9
3. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1131	1135	1 047	1 312	265	125.3
- Үүнээс эмэгтэй	тоо	696	673	552	660	108	119.6
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	349	263	262	309	47	118.0
4. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	851	883	443	449	6	101.4
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	675	883	333	449	116	134.8
Улирлын чанартай ажлын байр	тоо	176	0	110	0	-110	
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	444	460	546	589	43	107.9
- 10000 хүнд ногдох ***	тоо	106.7	110.6	128.2	137	9	106.9
6.Бойжиж буй төл, мян толгой	толгой	500.0	532.4	469.5	586.7	117	125
- Унага	толгой	19.6	19.9	12.8	21.6	9	0.0
- Тугал	толгой	16.4	17.5	12.8	16.6	4	130
- Ботго	толгой	5.5	6.0	6.0	6.7	1	0.0
- Хурга	толгой	227.0	250.3	236.6	286.9	50	121
- Ишиг	толгой	231.5	238.7	201.3	254.9	54	127
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	7999.3	7496.4	13608.5	131424.1	117815.6	9.6 ²
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	10283.1	7412.2	8530.6	207643.6	199113.0	24.3 ²

* - 2013, 2014, 2015, 2016 оны жилийн эцэст

**-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



II. ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БАЙДЛЫН ТУХАЙ СТАТИСТИКИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 10 сарын эцэст

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 I-X	2017 I-X	Өсөлт	
		тоо		хувь	
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	329.5	288.2	-41.3	87.5
2. Ор хоног	мян.хүн	93.5	93.8	0.3	100.3
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	12.6	9.5	-3.1	75.4
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	13	13.2	0.2	101.5
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	16.8	15.3	-1.5	91.1
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	3	2.6	-0.4	86.7
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	1990	2246	256	112.9
Үүнээс: нас баралт	хүн	64	71	7	110.9
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	1205	1304	99	108.2
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	1026	1122	96	109.4
8. Амаржсан эх	хүн	1197	1071	-126	89.5
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	2	1	-1	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	20	9	-11	45.0

1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн эхний 10 сарын эцэст

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1	1-5
				хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүртэл насны эндсэн хүүхэд
тоо					
Дүн	1071	0	1078	9	1
Айраг	3		3	1	
Алтанширээ					
Даланжаргалан	1				
Дэлгэрэх	1		1		
Иххэт	1		1		
Мандах					
Өргөн					
Сайхандулаан					
Улаанбадрах					
Хатанбулаг	3		3		
Хөвсгөл	2		2		
Эрдэнэ	1				
Сайншанд	842		850	3	1
Замын - Үүд	217		218	5	

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн эхний 10 сарын эцэст

Үзүүлэлт	2016 I-X	2017 I-X	Өсөлт	
	Тоо		Хувь	
Халдварт өвчний гаралт-Бүгд	1555	609	-946	39.2
Вируст гепатит	14	8	-6	57.1
Сүрьеэ	72	77	5	106.9
Тэмбүү	129	75	-54	58.1
Заг хүйтэн	115	110	-5	95.7
Трихоминиаз	80	64	-16	80.0
Цусан суулга	18	34	16	188.9
Бусад	1127	241	-886	21.4

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

ХОЁР. БОЛОВСРОЛ

2.1 БОЛОВСРОЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	Хэмжих нэгж	2016-2017	2017-2018	Өсөлт	
				тоо	хувь
1. ЕБС-Элсэлт	тоо	2649	3212	563	121.3
Үүнээс: Бага боловсролоор элсэгчид	тоо	1368	1553	185	113.5
Сурагчид	тоо	12278	12759	481	103.9
Үндсэн багш	тоо	600	625	25	104.2
2. МСҮТ - Элсэлт	тоо	283	360	77	127.2
Нийт сурагчид	тоо	606	597	-9	98.5
Үндсэн багш	тоо	35	34	-1	97.1
Хамрагдсан ААН	тоо	2	2	0	100.0
3. АШУҮИС - Элсэлт	тоо	131	141	10	107.6
-Анагаах, суурь сургалт /бакалавр/	тоо	63	70	7	111.1
-Сувилахуй /бакалавр/	тоо	24	15	-9	62.5
-Эх барихуй /бакалавр/	тоо	7	4		
-Бусад	тоо	38	52	14	136.8
Нийт оюутан	тоо	675	627	-48	92.9
Үндсэн багш	тоо	46	60	14	130.4
4. СӨБ - Элсэлт	тоо	1414	1637	223	115.8
Хамрагдаж байгаа хүүхэд	тоо	5232	5354	122	102.3
Үндсэн багш	тоо	164	167	3	101.8



ГУРАВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

3.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 10 сарын эцэст

Боловсролын түвшингээр	2014 X	2015 X	2016 X	2017 X	$\frac{2017 X}{2014 X}$	$\frac{2017 X}{2016 X}$
	хүний тоо				хувь	
ДҮН	1131	1 135	1 047	1 312	116.0	125.3
Үүнээс: Эмэгтэй	696	673	552	660	94.8	119.6
Магистр, доктор	9	6	8	7	77.8	87.5
Дээд боловсролтой	412	283	289	309	75.0	106.9
Тусгай дунд	102	134	110	96	94.1	87.3
Техник мэргэжлийн	93	116	122	106	114.0	86.9
Бүрэн дунд	449	382	373	682	151.9	182.8
Бүрэн бус дунд	290	129	115	80	27.6	69.6
Бага	60	29	20	13	21.7	65.0
Боловсролгүй	14	8	10	19	135.7	190.0

3.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 10 сарын эцэст

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
	2016 X	2017 X	2016 X	2017 X	2016 X	2017 X
ДҮН	1047	1312	295	518	1392	1244
Айраг	52	69	22	51	83	77
Алтанширээ	12	28	0	14	50	22
Даланжаргалан	50	57	11	54	59	71
Дэлгэрэх	17	16	40	16	49	26
Иххэт	35	24	14	3	46	15
Мандах	62	19	2	17	35	50
Өргөн	82	36	19	23	64	79
Сайхандулаан	33	17	0	7	35	42
Улаанбадрах	32	27	46	52	61	50
Хатанбулаг	14	45	11	9	69	49
Хөвсгөл	17	14	17	15	46	34
Эрдэнэ	12	25	21	37	50	51
Сайншанд	497	684	65	168	556	496
Замын - Үүд	132	251	27	52	189	182

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

3.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал 2017 оны 10 сарын эцэст

Салбарын ангилал	2016 X	2017 X
	Тоо	
Бүгд	61	652
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	3	12
Уул уурхай олборлох аж үйлдвэр	1	353
Боловсруулах үйлдвэрлэл		9
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	3	6
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа		4
Барилга	12	1
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	0	1
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	0	0
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	3	0
Мэдээлэл, холбоо	0	1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0	10
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0	0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0	0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	2	5
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	0	54
Боловсрол	0	35
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	13	26
Урлаг, үзвэр,тоглоом наадам	0	9
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	24	126
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн нэр төрлөөр нь салгаж тодорхойдох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ	0	0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0	0

3.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал 2017 оны 10 сарын эцэст

Үзүүлэлт	2016 X	2017 X
	Тоо	
Бүгд	51	652
Менежер	3	9
Мэргэжилтэн	3	122
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	20	96
Контор, үйлчилгээний ажилтан	5	30
Худалдаа, үйлчилгээний ажилтан	5	76
ХАА, ой загас агнуурын ажилтан	8	2
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний ажилтан	0	72
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	0	112
Энгийн ажил мэргэжил	7	126
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	0	7



3.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангилалаар 10 сарын эцэст

Үзүүлэлт	Бүгд	эмэгтэй
	тоо	
Бүгд	518	211
Менежер	11	2
Мэргэжилтэн	74	55
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	83	43
Контор, үйлчилгээний ажилтан	26	23
Худалдаа, үйлчилгээний ажилтан	70	52
ХАА, ой загас агнуурын ажилтан	3	1
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	46	6
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	92	6
Энгийн ажил мэргэжил	107	22
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	6	1

3.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 10 сарын эцэст

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар	
			Байнга	Улирал
	тоо			
Бүгд	449	139	449	0
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1		1	
Уул уурхай олборлолт	242	61	242	
Боловсруулах үйлдвэрлэл	37	7	37	
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент	6	3	6	
Барилга	74	20	74	
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ				
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	3	1	3	
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	1		1	
Мэдээлэл холбоо				
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1	1	1	
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	3		3	
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	11		11	
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	12	2	12	
Боловсрол	37	33	37	
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	9	4	9	
Урлаг үзвэр тоглоом наадам	1	0	1	
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	11	7	11	

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ДӨРӨВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

4.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА төрлөөр, жил бүрийн 10 сарын эцэст

Үзүүлэлт	Олгосон тэтгэвэр тэтгэмж		<u>2017 I-X</u>
	2016 I-X	2017 I-X	2016 I-X
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	20 230.4	22 281.4	110.1
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	12 190.7	13 384.2	109.8
Тэтгэмжийн даатгалын сангийн	1 376.8	1 516.9	110.2
Эрүүл мэндийн даатгалын сангийн	4 597.8	4 553.5	99.0
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	1 739.3	2 214.6	127.3
Ажилгүйдлийн даатгалын сангийн	325.8	612.2	187.9
Нийгмийн даатгалын сангийн зарлага	30 093.1	32 493.6	108.0
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	22 036.2	23 057.4	104.6
Тэтгэмжийн даатгалын сангийн	1 837.7	1 813.9	98.7
Эрүүл мэндийн даатгалын сангийн	4 481.7	5 061.6	112.9
ҮОМШӨ**-ний даатгалын сангийн	1 142.3	1 796.0	157.2
Ажилгүйдлийн даатгалын сангийн	595.2	764.7	128.5

** - ҮОМШӨ- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

4.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧДЫН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 10 сарын эцэст

Үзүүлэлт	хэмжих нэгж	2016 I-X	2017 I-X	<u>2017 I-X</u> 2016 I-X
1. Заавал даатгуулагч хүний тоо	тоо	15122	16830	111.3
Үүнээс: Аж ахуй нэгж, байгууллага	тоо	7282	8274	113.6
Төсөвт байгууллага	тоо	7840	8556	109.1
2. Олгосон тэтгэвэр	сая төгрөг	21744.2	23706.5	109.0
Үүнээс: Өндөр насны тэтгэвэр	сая төгрөг	15749.9	17437.8	110.7
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн тэтгэвэр	сая төгрөг	2556.1	2554.3	99.9
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	сая төгрөг	1117.6	1193.8	106.8
ҮОМШӨ-ний даатгалын сангийн тэтгэвэр	сая төгрөг	716.8	696.9	97.2
Цэргийн тэтгэвэр	сая төгрөг	1603.8	1823.7	113.7

Эх үүсвэр: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс



4.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 10 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		$\frac{2017 \text{ X}}{2016 \text{ X}}$	Олгосон тэтгэвэр тэтгэмж		$\frac{2017 \text{ X}}{2016 \text{ X}}$
	2016 I-X	2017 I-X		2016 I-X	2017 I-X	
	тоо		хувь	мянган төгрөг		хувь
1. Халамжийн тэтгэвэр	1,715	1,383	80.6	1,845,174.2	1,686,189.2	91.4
2. Нөхцөлт мөнгөн тэтгэмж: Үүнээс	8,901	8,653	97.2	1,817,351.1	1,792,517.7	98.6
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж	2548	2658	104.3	584,314.5	545,905.5	93.4
Ахмад настныг асарч буй иргэнд	698	590	84.5	266,867.6	283,067.1	106.1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд	477	319	66.9	114,248.7	150,634.1	131.8
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч буй иргэнд	412	230	55.8	165,159.1	125,663.7	76.1
Бүтэн өнчин хүүхэд асран хамгаалж үрчлэн авч өсгөсний тэтгэмж	95	55	57.9	30,306.4	31,186.1	102.9
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан хүүхдийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа иргэнд	55	8	14.5	25,371.2	3,567.0	14.1
Ганц бие ахмад настныг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа иргэнд	9	12	133.3	1,586.7	5,612.6	353.7
Ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа иргэнд	14	9	64.3	3,739.0	2,041.6	54.6
Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж	4593	4772	103.9	625757.9	644,840.0	103.0
